

ЛЕКЦИЙН ХИЧЭЭЛИЙН ҮР ДҮНГ ОЮУТНЫ БИЕ ДААСАН АЖЛААР САЙЖРУУЛАХ БОЛОМЖ (ХҮНИЙ ХӨГЖИЛ ХИЧЭЭЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Б.Ононтуул, Б.Хонгорзул

МУБИС-ийн БоСС, СӨБС

Ontl2001@yahoo.com, bhongoro_mz@yahoo.com

Хураангуй:

Энэхүү ажилд 2011-2012 оны хичээлийн жилийн нэгдүгээр хагаст МУБИС-ийн МоСС, ГХС-ийн 2-р курсын “Хүний хөгжил” сонгон судлах хичээлд хамрагдсан оюутнуудын тус хичээлийн талаарх үр дүнг, тэдний үнэлгээний материалд задлан шинжилгээ хийх замаар оюутны хөгжилд бие даасан ажлын хувь нэмрийг тодрууллаа. Нөгөө талаар БСШУСайдын 2006 оны 481 дүгээр тушаалаар “Хүний хөгжил” хичээл нь бакалаврын сургалтын төлөвлөгөөнд заавал сонгон судлахаар тусгагдсан бөгөөд агуулгын хувьд нийгэм, эдийн засаг, соёлын бүхий л асуудлуудыг тусгаж үздэгээрээ онцлогтой. Мөн лекцийн хэлбэрээр зохион явагддаг учир нэг дор олон оюутанд (100 орчим) зохион явагддаг учраас тэдэнд тодорхой мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэхийн тулд бие даах ажлын оновчтой, үр дүнтэй хувилбарыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна. Тиймээс оюутнуудын хэрэгцээ сонирхол, боломжид тулгуурлан бие даасан ажлын боломжит хувилбарыг тодруулахыг зорилоо. Судалгааг “Хүний хөгжил” сонгон судлах хичээлийг судалсан 255 оюутны үнэлгээний материалд тулгуурлан хийсэн болно.

Түлхүүр үг: Олон хувилбарт, бүтээлч үйл ажиллагаа, оюутны хэрэгцээ сонирхол, бүтээмж нэмэгдүүлэх хүчин зүйл, сургалтын чухал хэлбэр.

Оршил:

Их дээд сургуулийн бакалаврын түвшний /ялангуяа 2, 3-р курсын/ ерөнхий эрдмийн сонгон судлах хичээлийн хэлбэр нь лекцийн хэлбэрээр судлагддаг. Энэ нь оюутныг үйл ажиллагаанд татан оруулах, бүтээлчээр сурах, багш оюутны хамтын ажиллагааг өрнүүлэх, бодиттой үнэлэх, хүртээмжтэй ажиллах, агуулгыг цаашид дэлгэрүүлж судлах боломжуудыг хязгаарладагаараа сул талтай байдаг. Тиймээс энэ хэлбэрийн хичээл заадаг багш нарт лекцийн хичээлийн үр дүнг бие даасан ажлын хэлбэрээр сайжруулах зайлшгүй шаардлага үүсдэг. Нөгөө талаас оюутнууд хичээлийн агуулгыг дэлгэрүүлж судлах, оюутны идэвхи оролцоог нэмэгдүүлэх, оюутан өөрийгөө нээх, бусдад өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ байдаг. Ийм учраас багш оюутны хэрэгцээ шаардлагыг хангахын тулд бие даасан ажил чухал байр суурь эзэлж байна.

А. Оюутны бие даасан ажил, түүний ач холбогдол

Манай орны их дээд сургуулийн сургалтад “Оюутны бие даасан ажил” гэсэн ухагдахууныг олон арван жил хэрэглэсээр ирсэн бөгөөд жил ирэх тусам олон хувилбараар баяжигдан хөгжиж байна.

Өргөн утгаараа оюутны бие даасан ажил нь “Дээд боловсролын бүтээмжийг нэмэгдүүлэх чухал нөөц хүчин зүйл”, явцуу утгаараа оюутны хэрэгцээ, сонирхол, чадавхи зэргийг харгалзсан хичээлийн болон хичээлийн бус цагаар багшийн шууд бус удирдлага дор явагддаг оюутны бие дааж суралцах бүтээлч үйл ажиллагаа.

Их дээд сургуулийн сургалтад оюутны бие даасан ажлыг зохион байгуулж ирсэн туршлагад дүн шинжилгээ хийхэд: энэ ажлын зорилго нилээд ерөнхий, агуулга нь шинжлэх ухаанжсан, арга хэлбэр нь тогтсон цөөхөн хэдэн төрлөөр явагддаг, зарим үед хэлбэрдсэн гэж хэлж болохоор байна. Тухайлбал ихэнх оюутнууд багшийн өгсөн цөөн хэдэн сэдвээр бие даасан ажил хийх, оюутан ганц нэгхэн ном зохиол уншиж товчлон хуулж бичих, ямар шаардлагыг хангасан ажил хийх нь оюутанд тодорхойгүй, бие даасан ажлын үнэлгээг зөвхөн багш өгөх гэх зэрэг дутагдлууд элбэг байна. Иймээс ОБДА-ыг яаж сайжруулах вэ? Түүний үүрэг зориулалтад

ямар өөрчлөлт гарч байгаа вэ? Түүнийг үр өгөөжтэй болгох ямар боломж, арга зам байгаа вэ? зэрэг асуултад хариулах шаардлага бий болсон.

Иймээс “Хичээлийн агуулгыг оюутан хэрхэн өөрийн болгох вэ?”, “Ямар хэлбэрийг сонговол оновчтой вэ?”, “Үүний тулд багш юу хийх хэрэгтэй вэ?” гэсэн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Учир нь оюутанд сонголт хийх боломж олгосноор тэднийг илүү идэвхжүүлэх, хөгжүүлэх боломжтой болно.

Оюутны бие даасан ажил нь тэдний ирээдүйн ажилд хэрэг болох тийм практик, тулгамдсан /нэн чухал / асуудал байвал түүнийг оюутан одоо судалснаар сургуулиа төгсөөд тийм асуудалтай тулгарахад тодорхой хэмжээгээр шийдвэрлэх чадвартай болох талыг харгалзан боловсруулах нь зүйтэй.

Б. Оюутны бие даасан ажлаар лекцийн хичээлийн үр дүнг дээшлүүлэх боломж



Тус сургалтад 2 сургуулийн 2-р курсийн нийт 255 оюутан хамрагдсан бөгөөд бие даасан ажлыг ялгаатай байдлаар төлөвлөж ажилласан. Тухайлбал, 137 оюутанд урт хугацааны, хүч хөдөлмөр шаардсан бие даасан ажил (нэг сэдэвт зохиол уншиж судлах, туламдсан асуудлыг судлах, илтгэх) өгч, 118 оюутанд жижиг даалгавар өгөх замаар ажиллаа.

Оюутны өөрийн болгосон хичээлийн агуулгад дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн ажиглагдлаа.

Хүснэгт №1 Бие даасан ажлын ач холбогдлыг харуулсан харьцуулсан дүгнэлт

Бие даасан ажил гүйцэтгэсэн оюутнууд /84 оюутан/	Жижиг даалгавар гүйцэтгэсэн оюутнууд /118 оюутан/
<ul style="list-style-type: none"> ✓ Өөрийн бие дааж ажилласан сэдвээ илүү сайн тайлбарласан. ✓ Илүү их зүйлд суралцсан. ✓ Өөрийгөө нээсэн. 	<ul style="list-style-type: none"> ✓ Лекцийн хичээлийн агуулгад чиглэсэн. ✓ Идэвхгүй байр сууринаас хандаж байсан. ✓ Хэрэглээ болоогүй мэдээлэлтэй байсан.

Шигтгээ №1 Оюутны бие даасан ажлын ач холбогдол, үр дүнгийн талаар санал

Оюутнуудаар илтгэл тавьсан нь зөв оновчтой санаа байсан. Яагаад гэвэл илтгэлд бэлдэх явцдаа бид:

- -тухайн сэдвийн хүрээнд мэдлэгтэй болсон
- илтгэлийн бүтэц, дараалал, шаардлагыг мэдсэн
- олон хүмүүсийн өмнө илтгэх, ярих зэрэг олон чадвартай болсон.

О-26-ын үнэлгээний хуудас

Миний хувьд илтгэл тавьснаар их зүйл сурч авсан.

О-94-ын үнэлгээний хуудас

Presentation тавьсан хичээл бүр тодхон санагдаж байна. Бид “дэлхий бөөрөнхий биш” номны бүлгүүдийг уншиж судалсан. Үүнээс олон санал, санаачилгыг харж, хэрэгжүүлж, болохуйц байсан. Их сонин шийдэл, үг хэллэгтэй бүлгүүдтэй танилцсан. Өөрсдөө бүтээлчээр сэтгэн, хөгжссөн хичээл байлаа.

О-52-ын үнэлгээний хуудас

Мэдээллийн эрин зуунд суралцагчдад МХТ-ийг ашиггах чадвартай болгох хэрэгтэй. Мөн илтгээ тавих замаар сургах нь илүү үр дүнтэй санагдсан. Яагаад гэвэл бэлэн зүйл дээр ажиллах бус өөрсдөө эрж хайж бүтээлчээр суралцах нь бидэнд хэрэгтэй.

О-59-ын үнэлгээний хуудас

Тэгэхээр бие даасан ажил нь оюутныг үнэлэхээс илүүтэй тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд илүү хувь нэмэртэй гэдэг нь харагдаж байна. Нөгөө талаас оюутан өөрийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд илүү сайн суралцах боломж бүрддэг байна.

Хүснэгт №2 Лекцийн хичээлийн үр дүнг дээшлүүлэх боломж:

Сургууль, багш нарын хүрээнд шийдвэрлэж болох	Сургууль, багш нарын хүрээнд шийдвэрлэх боломжгүй
<ul style="list-style-type: none"> a. Бие даасан ажил хийлгэх 11 b. Гарын авлага, сурах бичгээр хангах 23 a. Бичил судалгаа хийх 25 b. Эрдэмтэн судлаачтай уулзаж, нээлттэй хэлэлцүүлэг хийх 33 c. Баг болон хуваагдан оюутан өөрөө хичээл зохион байгуулах 12 d. Байгууллагуудтай хамтарч ажиллах 1 e. Мэтгэлцээн, тэмцээн уралдаан зохион байгуулах 31 f. Илтгэл бичиж тавиулах 46 g. Клуб байгуулж ажиллах 8 h. Бүтээлийн сантай болох 4 i. Мэргэжлийн хичээлтэй холбох 16 j. Бүтээлч даалгавар өгөх 1 k. Төсөлт ажил зохион явуулах 1 l. Ном судлах 1 	<ul style="list-style-type: none"> m. Цагийн багтаамжийг нэмэгдүүлж, семинарын хичээлтэй болох 164 n. ЕБС-д хичээлээр оруулах 86 o. Заавал судлах хичээл болгох 65

Эндээс харахад:

1. Нийт саналын 155 нь бие даасан ажлын төрөл хэлбэрийг олон хувилбартай болгох
2. Мөн оюутны бүтээлч үйл ажиллагаанд тулгуурласан байх
3. Оюутнууд хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх, багаар ажиллах чадварт суралцах
4. Сургалтын агуулга, аргазүйг зөвхөн танхимын төдийгүй танхимаас гадуурх үйл ажиллагаатай холбож өгөх
5. Багш сургалтын үйл ажиллагааг гуравдагч субъектүүдтэй хамтарч зохион явуулах зэрэг хэрэгцээ байдаг нь ажиглагдаж байна. Тиймээс лекцийн хичээлийн үр дүнг дээшлүүлэх нэг боломж нь оюутны бие даасан ажлыг олон хувилбартай, оюутны хэрэгцээнд тулгуурлаж, олон талын үйл ажиллагааны хэлбэрээр зохион явуулахаар төлөвлөх юм.

ДҮГНЭЛТ

1. Лекцийн хичээлийн үр дүнг оюутны бие даасан ажлаар сайжруулах боломж байна.
 - a. Хэрэгцээ сонирхлыг нь харгалзах: бие даалтын төрөл хэлбэр, судлах сэдвийг сонгуулах
 - b. Судлагдахууны онцлог харгалзан олон хувилбартай байх
 - c. Багаар ажиллуулах
 - d. Судалгаа шинжилгээ хийх, тайлагнах
 - e. Мэргэжлийн онцлогыг харгалзаж, хичээлийн агуулгыг интеграцчилж ажиллах г.м.

2. Оюутнууд ном зохиол уншиж судлаж илтгэл тавих, эрдэмтэн судлаачтай уулзаж, нээлттэй хэлэлцүүлэг хийх, бичил судалгаа хийх (төсөлт ажил), баг болж хичээл зохион байгуулах, мэтгэлцээн, тэмцээн уралдаан зохион байгуулах сонирхолтой байдаг байна. Тиймээс бие даалтын ажлыг төрөл хэлбэрийг оюутантай зөвшилцөн тэдний саналд үндэслэж уян хатан боловсруулж хэрэгжүүлж болох юм.
3. Оюутан бие даасан ажил гүйцэтгэснээр зөвхөн тухайн судлагдахууныг эзэмшихээс гадна өөрийгөө нээж, хөгжүүлэх туршлагыг хуримтлуулдаг.
4. Лекцийн хичээлээр суралцаж буй тохиолдолд цагийн багтаамж бага байдагтай холбоотойгоор тодорхой бэрхшээл тулгамддаг. Үүнийг шийдвэрлэхэд хамгийн оновчтой арга зам нь сургалтын хугацааг нэмэхгүйгээр оюутнаар бие даалгаж тодорхой зүйл хийлгэх, хийсэн зүйлээ хамтран хэлэлцэж хамгаалах ажлуудыг тасралтгүй хийх явдал юм.

Ашигласан ном, хэвлэл

1. Батхуяг С., нар. Дээд сургуулийн сурган хүмүүжүүлэх зүй. УБ., 2003
2. Даваа Ж., нар. Дээд сургуулийн сургалтын технологи. УБ., 2007
3. Наранцэцэг Я., нар. Дээд сургуулийн заах аргазүй. УБ., 2001

Зохиогчийн тухай:

Банзрагчийн Ононтуул.

МУБИС-ийн БСС-ийн Боловсролын Судалгаа – Аргазүйн тэнхмийн залуу багш. 2001 онд МУИС-ийн ОУХДС-ийн бакалавр, 2004 онд МУБИС. БСС-ийн боловсрол судлалын магистр, 2010 оноос МУБИС. БСС-ийн боловсрол судлалын докторантурт элсэн суралцаж байна. Судалгааны ажлын чиглэл боловсрол судлалын асуудлууд, Боловсрол дахь хүний хөгжлийн асуудлууд болно.

Баттулга Хонгорзул

МУБИС-ийн СӨБС-ийн Сурган хүмүүжүүлэх ухаан, Сэтгэл судлалын тэнхмийн залуу багш. 2007 онд МУБИС-ийн БУС-ийн бакалавр, 2008 онд МУБИС-ийн БСС-ийн боловсрол судлалын магистр. Судалгааны ажлын чиглэл оюутны бие даасан ажил, оюутны бүтээлч үйл ажиллагаанд багшийн гүйцэтгэх үүрэг болно.